

08 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: 2020 оныг аймгийн “Залуучуудыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн ИТХ-ын даргын ивээл дор Монголын залуучуудын холбооны "Андын гэрэгэ" гардуулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээг аймгийн ИТХ, Залуучуудын холбоотой хамтран зохион байгууллаа.

б. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Тулгар төрийн 2229 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмын сурын харваанд түрүүлж “Монгол Улсын мэргэн” цол хүртсэн Л.Одсайханы цолны мялаалга наадам Баруун-Урт суманд боллоо. Сүхбаатар аймгаас төрөн гарсан анхны мэргэний цолны мялаалга наадамд Монгол Улсын үлэмж мэргэн Ц.Хүдэрчулуун, даян мэргэн Б.Ёндон, дархан мэргэн Х.Оюунчимэг, даян мэргэн Д.Эрдэнэтуяа тэргүүтэй улс аймгийн цолтой 250 гаруй харваач оролцлоо. Наадмын үеэр сур харваа, шагайн харвааны тэмцээнүүд зохион байгуулсан бөгөөд энэхүү тэмцээн нь тус аймагт төдийгүй зүүн бүсийн хэмжээнд болж буй хамгийн анхны том тэмцээн гэдгээрээ онцлог байлаа.

Монгол Улсын мэргэн Л.Одсайханд аймгийн ЗДТГ, ИТХ-ын зүгээс хүндэтгэл үзүүлж Баруун-Урт сумын төвд шинээр баригдаж буй “Даймонд таун” хотхоны нэг өрөө байрыг олголоо.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

Энэ сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 30,911,5 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 4,722,6 сая төгрөгийн орлого орж нийт 35,634,1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

Эхний 8 сарын байдлаар Улсын төсөвт 2037.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 1488.9 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 73,1 хувиар, Орон нутгийн төсөвт 6214,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 6411,7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100.2 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 3,856,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 33,944,1 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллаг

ОНХНС-ийн орлогын шилжүүлэг төлөвлөгөө 5810803,7 мян.төгрөгөөс гүйцэтгэлээр 5462473,2 мян.төгрөг шилжиж ирсэн. Сумдад итгэлцүүрийн дагуу 1916201,2 мян. төгрөг хуваарилж шилжүүлсэн. Аймгийн ОНХС-аар хийгдэж буй хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний гүйцэтгэл / өссөн дүнгээр/ 1459562,8 мян.төгрөг, удирдлагыг болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний гүйцэтгэл 619897,8 мян.төгрөг байна.

2021 оны төсвийн төсөл боловсруулах удирдамж чиглэлийн дагуу 2021 оны аймгийн төсвийн орлогын санал, 2022-2023 оны орлогын төсөөллийг батлагдсан маягтын дагуу гаргаж Сангийн яаманд хүргүүлж ажиллалаа.

2021 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийг яаманд цахимаар илгээн хянууллаа.

13 төсвийн төвлөрүүлэн захирагчийн болон төсвийн шууд захирагчийн 2020 оны 2 дугаар улирлын Санхүүгийн тайланг шалгаж хүлээн авч хуулийн хугацаанд Сангийн яаманд цахимаар өгч “шилэн дансны цахим сан”-д байршууллаа.

Орон нутгийн өмчийн газар: 8 дугаар сард нийт 4,697,100,000 төгрөгийн 5 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг цахимаар зарласан бөгөөд үр дүн гарсан 1 тендер, хүлээн авах хугацаа дуусаагүй 4 тендер байна. Мөн тухайн сард 6 нэр төрлийн тендерийн нээлт хийж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж захиалагчид холбогдох зөвлөмжийг /нийт 1,026,509,169 төгрөг/ хүргүүлсэн байна.

Өмчийн бүртгэл, хяналтын хүрээнд: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу орон нутгийн өмчит 2 байгууллагаас ирсэн санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 31 дүгээр тогтоолын дагуу нээлттэй дуудлага худалдааг 08 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж “Тохижилт-Үйлчилгээ ОНӨААТҮГ-ын УАЗ маркийн 17-99 СУА дугаартай фургон автомашиныг 1,700,000 төгрөгөөр худалдсан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Баруун-Урт сумын иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Сүхбаатар-Уул уурхай ОНӨААТҮГазарт санхүүгийн хяналт шалгалт хийж хуулийн байгууллагад шилжүүллээ. Мөн албаны даргын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Сүхбаатар Тохижилт-Үйлчилгээ ОНӨААТҮГазрын 2019-2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Статистикийн хэлтэс: Хөдөө аж ахуйн түүвэр судалгааны /Малын ашиг шим болон газар тариалангийн судалгаа/ эхний 2 улирлын мэдээллийг сонгогдсон 8 сумын 8 багийн 160 өрхөөр бөглүүлэн татан авч, хянаж шалгах ажил хийж, програмд оруулан Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь хүргүүлээд байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 8-р сарын мэдээллийг 8 сумын 11 нэгжээс 102 өрхөөс цуглуулалтын ажиллаж байна.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлагийн чиглэлээр: Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн боловсролын салбарын удирдах ажилтнуудын хамарсан “**2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ, АНХААРАХ АСУУДАЛ**” сургалт, семинар зохион байгууллаа. Сургалтад 24 цэцэрлэг, 16 сургууль, нэгдсэн дотуур байр, насан туршийн боловсролын төвийн захирал, эрхлэгч, сургалтын менежер, эмч, нийгмийн ажилтан, БСУГ-ын мэргэжилтэн нийт 100 албан хаагч хамрагдлаа. Сургалт, семинарын үеэр НБХ, ЭМГ, ОБГ, МХГ, СХЗГ зэрэг холбогдох байгууллагуудын мэдээллийг танилцуулж санал солилцлоо. Мөн “**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ЗҮЙ**” 2 өдрийн сургалтыг 15 судлагдахуунаар цахим болон танхим хэлбэрээр зохион байгуулж 400 гаруй багш хамрагдсан ба Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулж буй “**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ЗҮЙ**” сэдэвт цахим сургалтад ЕБС-ийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, номын санч, СӨББ-ын эрхлэгч нийт 50 хүн 1 сарын хугацаатай хамрагдаж байна.

Боловсрол, соёлын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилгын болон их засварын ажлын явцтай танилцан Халзан, Баяндэлгэр, Онгон, Наран сумдад ажилласан.

БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар Хөгжимт жүжгийн театрт 45 хүний суудалтай автобус, Халзан сумын Соёлын төвд 48 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж олголоо.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Биеэр болон утсаар хандсан 5 иргэнд зөвлөгөө өгч, гэр бүлийн нэгжтэй хамтран цагдаагийн газар саатуулагдаж буй архины хамааралтай 13 иргэнд Гэр бүлийн харилцаа, Хүүхэд хамгааллын талаарх сургалтыг явууллаа.

Хүүхдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гитар болон дууны дугуйланд 20 хүүхэд, хүүхдийн уншлагын номын сантай хамтран 1 сарын хугацаанд Харилцаа хандлага, Цахим хэрэглээ, Хүүхдэд зөвлөмж буюу сурагчийн аюулгүй байдлын талаарх 9 удаагийн сургалтад 37 хүүхдийг хамруулсан.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль болон Залуучуудын хөгжлийн төвийг сурталчлах, нийгмийн хөгжилд залуучуудын оролцоог ханган эрх үүргийг тодорхойлж, идэвхжүүлэх, төрөөс залуучуудын талаар баримталж буй бодлого хөтөлбөрийг олон нийтэд таниулах зорилгоор өдөрлөг зохион байгуулж 146 залуучуудыг хамруулсан. Өдөрлөгийн үеэр өглөөний дасгал хөдөлгөөн, хөгжөөнт тэмцээн, АХА тэмцээн мөн цусны төвтэй хамтран сайн дураараа цусаа бэлэглэх, сэтгэл зүй, эрхзүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн.

“Нэгүн” Залуучуудын оролцооны байгууллага 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Угсаатны зүйн музей: “Дэлхийн монголчуудын радио-88,3”-т Дарьганга сумын Дархан Нацагийн Амартайвангийн урласан “Төрдөг мөнгөн аяга”-ны талаарх мэдээ мэдээллийг өгч үзмэр эд өлгийн зүйлийг сурталчиллаа.

Үзмэр эд өлгийн зүйлийг сурталчлах үүднээс “Шашин”, “Мөнгөн урлал”, “Шилдэг-10”, “Хөөрөг”, “Цом” зэргээр 5 төрлийн ил захидлыг хэвлүүлж, худалдаанд гарган үзмэр эд өлгийн зүйлээ сурталчилж байна.

Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаагаар ахлуулсан баг ажиллаж, Эрдэнэцагаан сумын Хаалгатын хүн чулуунд хэмжилт хийлээ.

Хөгжимт жүжгийн театр: Зүүн Монгол Дорнын гоёл” дуу, хөгжим, бүжгийн чуулбарыг дүрсжүүлэх, 1988 оны ахмад бүжигчдийн бүжгийг архивлах ажлыг 8 сарын 10-наас 8 сарын 15 хүртэл Дарьганга суманд хийсэн.

Хөгжим ангийн уран бүтээлчид Говь-Алтай аймаг руу УГЗ н.Аюушийн нэрэмжит цөөхүүл хөгжмийн уралдаанд оролцохоо бэлтгэл ажилдаа орж байна.

Нийтийн номын сан: Байнгын уншигч 73, Ирэгсэд 348, Ном олголт 497 “Зуны зугаатай уншлага” 1 сарын аяныг амжилттай зохион байгуулсан. Энэ хугацаанд нийтдээ шинээр 36 хүүхдэд карт нээж, 276 ирэгсдэд 325 номоор үйлчилсэн.

"Мэдээллийн цаг"-1 булангаараа хүүхэд багачууддаа зориулан "Монголын нууц товчоо" номын тухай мэдээлэл өглөө. Мөн манай номын санд байгаа "Монголын нууц товчоо" номоор үзэсгэлэн гаргаж үйлчиллээ. "Мэдээллийн цаг"-2 булангаараа хүүхэд багачууддаа зориулан "Ургийн бичиг хөтлөхийн ач тус" сэдвээр мэдээлэл өглөө.

"Зуны зугаатай уншлага" аяны хүрээнд "Танин мэдэхүйн аялалын цаг" булангаараа аймгийн төвийн хөшөө дурсгалын газраар явган аялал хийж танин мэдэхүйн аялал, Найзтайгаа уншъя" Уншлагаар Тэмүүлэл цогцолборын сурагчид. 3-р сургуулийн сурагчид оролцож "Өглөөний гайхамшиг" номын талаар ярилцлага зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2020 оны 8-р сарын байдлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажил хайгч 725, үүнээс эмэгтэй 366 байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 492 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 334 иргэн ажлын байранд зуучлагдан, шинэ ажлын байр 243 бүртгэгдсэн байна.

ХХҮГазраас 2017-2019 онуудад хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 25 иргэнтэй утсаар холбогдож 7 иргэний эргэн төлөлтийн хугацааг хойшлуулж гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Нийгмийн халамжийн талаар: 2020 оны 08 дугаар сард ХХҮГ-н дэргэдэх ахмадын амралт сувилалд 98 ахмад амарч, бариа засал, бумба, зөгийн балны татлага, цахилгаан массажны аппарат, хаш чулуун ор, төөнүүр, шарлага зэрэг сэргээн засах эмчилгээнүүдийг хийж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахаар өргөдөл хүсэлт гаргасан иргэдийн анхан шатны баримт бичгийг хүлээн авч, программд нийт 150 иргэний үйлчилгээг бүртгэж баталгаажуулж, олголтыг үүсгэлээ.

Цахим Монгол хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас нийгмийн халамжийн үйлчилгээг цахимд шилжүүлэх ажлын хүрээнд 13 сум болон хэлтсүүдэд тус бүр нэг нийт 16 ширхэг 1496000 төгрөгийн үнэтэй хурууны хээний төхөөрөмжийг байршуулаад байна.

Монгол улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банкттай хамтран 2020 оны 8 дугаар сарын 24-25 –ны өдрүүдэд Дундговь аймагт зохион байгуулсан “Салбар орон нутгийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа сургалтанд тус аймгаас төрийн албан хаагч -3, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 5 хамрагдлаа.

Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Дарьганга сумын Засаг даргын захирамжийг хянасан.Сүхбаатар дүүргийн анхан шатны шүүхэд иргэний нэхэмжлэлийг боловсруулан явуулсан Эрдэнэцагаан сумын Бичигт боомт дахь Тамгын газрын 9 айлын орон сууцанд амьдрах алба хаагч нартай өмч эзэмшүүлэх гэрээ байгуулсан.

Улсын бүртгэлийн чиглэлээр: Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ.

Хүлээн авсан мэдүүлгийн тоо 175, анхны бүртгэл 24, өмчлөх эрх шилжих гэрээ 23, барьцааны гэрээ 114, бүртгэлд өөрчлөлт оруулах 1 лавлагаа хуулбар 9, нийт бичигдсэн гэрчилгээний тоо 48,

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ:

Хүлээн авсан мэдүүлгийн тоо 170, анхны бүртгэл 15, өмчлөх эрх шилжих гэрээ 30, барьцааны гэрээ 101, бүртгэлд өөрчлөлт оруулах 6, лавлагаа хуулбар 3 нийт бичигдсэн гэрчилгээний тоо 51, нийт бичигдсэн лавлагааны тоо 3

Хуулийн этгээдийн бүртгэл: 08 дугаар сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1204. Үүнээс ХК 1, ХХК 630, төрийн бус байгууллага 118, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар 1, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар 21, Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар 137, нөхөрлөл 76, хоршоо 79, хадгаламж зээлийн хоршоо 4, сан 3, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 43, шашны байгууллага 13, хэвлэл мэдээллийн байгууллага 2 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн 423, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд 63, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн 201, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт 458, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон 425, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 177-г тус тус бүртгээд байна. Тухайн сард лавлагаа нийт 7-г олгосноос Хууль хяналтын байгууллагад 6, иргэн хуулийн этгээдэд 1 лавлагааг тус тус олгосон байна.

Иргэний бүртгэл: Иргэний бүртгэлийн тасаг нь 2020 оны 08 дугаар сарын байдлаар нийт 140 төрөлт, гэрлэлт 34, гэрлэлт цуцлалт 6, үрчлэлт 1, эцэг тогтоолт 9, овог нэр өөрчлөлт 7, нас баралт 35, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 184, үндэсний энгийн гадаад паспорт 5, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 96, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 273 тус тус бүртгэгдэж олгосон байна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр: Тус газрын хорихоос өөр төрлийн ялын хяналтад 2020 оны 08 дугаар сарын байдлаар торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 11 ялтны 42470,0

төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 106 ялтны 92350,0 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 99 ялтны 80.20.0 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 18 ялтны 54800.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх урьд оны үлдэгдэл 7 ялтны материал дээр шүүхээс шинээр 19 ялтны 7440 цагийн ялын материалыг хүлээн авч, 9 ялтны 4119 цагийг хорих ялаар солиулж, 1 ялтны 320 цагийг шүүхээс хүчингүй болгож, 25 ялтны 10512 цагийн ялын хугацаа дуусаж, үлдэгдэл 2 ялтны 1051 цагийн ял эдлэлтэд хугацаа тавин ажиллаж байна.

Эрх хасах ялын урьд оны 24 ялтны 15758 хоногийн үлдэгдэл дээр 6 ялтны 5475 хоногийн материал нэмэгдэж, 1 ялтны 1825 цагийг үндсэн ялаа эдэлж дууссан үндэслэлээр нэмэгдэж, үлдэгдэл 28 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны үлдэгдэл 2 этгээдийн 10000,0 төгрөг материал дээр шүүхээс шинээр 26 этгээдэд холбогдох 29312,0, нийт 393312,0 төгрөгөөс 20 этгээдийн 12116,4 төгрөгийн хөрөнгө орлогын хураасан авч орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр: Нийт 690 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаас: Төлбөрийн биелүүлбэл зохих 419 гүйцэтгэх баримт бичгийн 2717819.0 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулснаас 204 гүйцэтгэх баримт бичгийн 465105.5 мянган төгрөгийн төлбөрийг биелүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 51.7 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлгийн 271 гүйцэтгэх баримт бичгийн 741385.2 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, хэсэгчлэн 170 гүйцэтгэх баримт бичгийн 349580.5 мянган төгрөгийг төлүүлж, 23 гүйцэтгэх баримт бичгийн 387191.4 мянган төгрөгийг дуусгавар болгон нийт 736771.9 мянган төгрөгийг биелүүлсэн ажилласан.

Шүүхийн шинжилгээний алба: Албаны бие бүрэлдэхүүн Цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнд орж ажиллан жижүүрт 30 удаа ооаа аад÷ аэеэеапиааи дүгидеэ аиу иан дидеэни дүдаеэи аооаааааа 11 оааа, доеааеи дүдаеэи аооаааааа 6 оааа, çàì òúúâðèèí ìñèúí áóóæääááá 8, бусад хэргийн дуудлаганд 3 оааа, иеёо 28 удаа дүдаеэи ааçдúí ççèúâð ìðèòíí òúðàèèí áàçдúí ççèúâúúð áòðèúí ìð 11 øèðдóú, áàдúí ìð 8 øèðдóú, òúúâðèèí òúðúâñèèèí ìð 4 ширхэг, бичил мөр 0 ширхэг, биологийн гаралтай мөр 0 ширхэг, эвдлэгч багажийн мөр 1 ширхэг аонна оё ìð 5 ширхэг, ул мөр илрээгүй үзлэгийн тоо 14 ширхэг иеёо 29 оё ìð èèðççè, áúðæççèýí òòàááí áàèà.

Оон аеааиу оеиæý÷ ÿì÷ íàð íú 08 дугаар сарын ааеаааад хүний биед аүйдөөеи çýдóú òíàðíð ççèú 92 оааа ðèèñíúúñ ðçíà 4, ðçíàúâðýð 6, ð°íà°í 22, аүйдөөеи çýдóúð òàíààðàðæçé 28, аүйдөөеи çýдóú òíàðíñáñæçé 32 æçííýèð áàðàñàí áàèà. Бүеэеи холбогдолтой 1 шинжилгээ хийсэн байна. Гүйд дүдаеэи áíèíí áóñàà øàèðàááááð ìàñ áàðñàí 10 ðçíà øççð ÿííýèèèí çààèáí øèæèèæýú хийæ æçííýèð áàðàèèà. Ì°í çààèáí øèæèèæýúèèè ÿàòàà òíàðíñííñ ÿâ ÿððòúýèè æúúæ ìàðàðèèè áíèíí òòñàí áàðú ÿðèèèèí ñèððòúí òòáú òúíæúúá òíàíððèèèð çðèèèñíð çàáááð æòðíúí áàáóó æúúæ ìàðàðèèèúá áá÷, èàáíðàððèèð òèèèèí 15 øèæèèæýú òèèæ æçííýèð áàðàèèà. Аеаиé ñèèèíáð ææèúí ñòàíòàáð иеёо 31 хүний гарúí áàðàáñ áá÷ Áàèñ-Ìàèèèí ææèúí ñòàíòúí ñàíá ááúæòòèàн ажиллаа.Нийт 780 кадр гэрэл зураг авагдсан байх ба шинжилгээний 20, хэргийн газрын үзлэгийн 517, цогцосны гадна үзлэг болон задлан шинжилгээний 203, бусад ажиллагааны 40 кадр гэрэл зураг авагдсан.

Тав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:

Хөдөө аж ахуйн салбарт: Зах зээл ба бэлчээр менежментийн удирдлагын хөгжил төслөөс хэрэгжүүлж буй “Инженерийн хийцтэй худаг шинээр барих” багц-1 ажилд “Оргилон дэлгэрэх сүм” ХХК, багц-2 ажилд “Монгео физик” ХХК тус тус шалгарч ажил гүйцэтгэх гэрээ хийж хамтран ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр “Угаалгын ванн шинээр барих” багц-1,2 тендэрт “Смартлифт” ХХК, “Инженерийн хийцтэй гүний худаг барих” багц-3 тендэрт “Голден хилл” ХХК тус тус шалгарч гүйцэтгэх ажлын гэрээ хийж хамтран ажиллаж байна.

Аймгийн жишсэн дундаж хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, нийтийн хоолны салбарын хүнсний нөөцийн судалгааг сумдаар нэгтгэн гаргаж 7 хоногийн 3 дахь өдөр сумдын хүнсний дэлгүүр, худалдааны төв, мал, мах бэлтгэн нийлүүлэгч нараас хүнсний бүтээгдэхүүний хангамж, нөөц, түүхий эдийн нөөц талаарх мэдээг ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ хүргүүлж ажиллалаа.

Жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангийн зээлийн ахлах мэргэжилтэн А.Мөнх-Эрдэнэ Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Баяндэлгэр Баруун-Урт сумдын жижиг дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээл хүссэн нийт 18 зээлдэгчийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үнэлгээ хийж ажилласан.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд 2019, 2020 онуудад Эрдэнэцагаан, Дарьганга, Баяндэлгэр, Түвшинширээ, Уулбаян, Баруун-Урт сумдад хийгдэж буй, өвс тэжээлийн агуулах, сарав, мал угаалгын ванн, инженерийн хийцтэй гүн өрмийн худаг ажлын явцад хяналт шинжилгээ хийлээ. Ажил гүйцэтгэх явцдаа илэрсэн алдаа дутагдал, дахин хийх ажлуудын талаар гүйцэтгэгч компаниудад албан бичгээр хүргүүлсэн.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт” төслөөс санхүүжүүлж буй “Мал үржүүлэг технологийн багаж хэрэгсэл, цөм сүргийн мал үржүүлэх ажлын тендер”-ийг зарлахад бэлэн болоод байна.

Мал эмнэлгийн газар: Мал, амьтны шимэгчтэх өвчинтэй тэмцэх арга хэмжээг сайжруулах, ажлыг идэвхижүүлэх зорилгоор “Мал угаалгын ажил”-ын нээлтийг Баруун-Урт суманд 3-н аргаар угаалга хийж, зохион байгуулан 13 сумын МЭ-ийн тасаг, 56 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд үүрэг, чиглэл өгч ажиллав.

Боловсруулалтад 617.3 мянган мал хамрагдахаас үхрийн арьсны гуурын боловсруулалтанд 268547 үхэр хамрагдахаас **112587** хамрагдаж 41,9 хувийн гүйцэтгэлтэй, бусад боловсруулалтад 3039 адуу, 12046 үхэр, 162556 хонь, 94538 ямаа нийт **272179** мал хамрагдаж 78,0 хувийн гүйцэтгэлтэй, туулгалтад 712000 мян толгой мал хамрагдахаас 19154 адуу, 32915 үхэр, 303190 хонь, 190799 ямаа, 7025 нохой нийт **553083** мал хамрагдаж 77,8 хувь, мал угаалганд 3487200 мян толгой мал хамрагдахаас 1025 тэмээ, 56036 үхэр, 896247 хонь, 346817 ямаа нийт **1300125** мал хамрагдаж 37,3 хувийн тус тусын гүйцэтгэлтэй байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/447 дүгээр захирамжаар бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 879,1 мянган төл малыг хамруулах ажил 8 дугаар сарын 10 өдрөөс эхлэн хийгдэж байна. Одоогоор вакцинжуулалтын явц 28,2 хувьтай хийгдэж байна.

Шүлхийн вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд Сүхбаатар, Эрдэнэцагаан, Дарьганга сумдын 15 багийн 45 малчин өрхийн 675 дээжийг авч шинжилгээнд хамруулсан.

Аймгийн хэмжээний хээлтүүлэгчийн шинжилгээг 19905 малаас дээж хариуг гарган сумдын МЭ-ийн тасагт хүргүүлэн ажиллаж байгаа ба хээлтүүлэгч малын шинжилгээг 100 хувь гүйцэтгээд байна.

Дарьганга өртөө ХХК, Хараацайн жигүүр ХХК-ны нийтийн тээврийн хэрэгсэлд өдөрт тутам халдваргүйтгэлийг хийж байна.

Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 7 дугаар сарын 30-ны өдөр бүх сумдын Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд Дижитал Медик компаниас давтан сургалтыг УМЭЕГ-тай хамтран зохион байгуулж нийт 68 малын эмч, мэргэжилтэн нар оролцлоо.

2020 онд орон нутгийн төсөвт 33,8 сая төгрөгийг батлуулан мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт зөөврийн принтер 56 ш, 13 тасгийн мэргэжилтэн нарт tablet, мал эмнэлгийн газарт хяналтын иж бүрэн компьютертэй боллоо.

Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар хэрэгжүүлж буй “Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” ТТ-9751 мон төслөөс “Хөдөө аж ахуйн бизнес” сэдэвт сургалтыг 08 сарын 12-ны өдөр зохион байгуулж, 3 сумын нийт 25 бизнес эрхлэгчийг хамруулан, бизнесийн салбарт нөлөөлөх “Нийгмийн хүчин зүйлс”-ийн авсан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/486 дугаар захирамжаар Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйлчилгээ үзүүлдэг 2 аж ахуй нэгжийн эрхийг сунгаж, 2 аж ахуй нэгжид шинээр эрх олгосон байна.

Зургаа. Бусад салбарт хийгдсэн ажил:

Онцгой байдлын газар: Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/50 дугаар тушаал “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжих тухай”, Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн А/44 дүгээр тушаал “Холбоо зохион байгуулах горим, тоон шифр батлах тухай”, болон газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн даргын баталсан “Ажлын байрны ногоон орчин бүрдүүлье” аяны удирдамжийн хэрэгжилтийг тус тус хангаж ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Боловсролын байгууллагуудад хийх төлөвлөгөөт, шингэрүүлсэн шатдаг хий ашигладаг аж ахуйн нэгж байгууллагад хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалт”-ын удирдамж, холбогдох стандарт, техникийн норматив, дүрэм, журмын дагуу зохион явууллаа.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нийт 21 аж ахуйн нэгж байгууллагад явуулснаас 96 зөрчил илрүүлж, үзлэг шалгалтын явцад 37 зөрчлийг арилгуулж, 52 зөрчлийг арилгуулахаар 7 заавал биелүүлэх албан шаардлага 4 мэдэгдэл хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Галын аюулгүй байдлын тухай хууль, аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр танхимын сургалт болон гал унтраагуур ажиллуулах талаар дадлага сургуулийг 55 ажилтныг хамруулан зохион явууллаа. Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар заавар зөвлөмж өгч ажилтан алба хаагч нарын мэдвэл зохих хууль, дүрэм, гал унтраах багаж хэрэгслийг ажиллуулах заавар, зэргийг гарын авлага материалыг боловсруулан хүргүүлэн ажиллалаа.

ОБЕГ-ын даргын 2018 оны А/02 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Галын аюулгүй байдал нь хангагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 4-ийг гаргаж, 1 барилгын зураг хянаж, хураамжийг аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлэн ажиллалаа.

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар:

“Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Үер усны аюулаас урьдчилан сэргийлье”, “Хээрийн түймрээс урьдчилан сэргийлье”, “Ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлье”, “Ковид-19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлье” сэдэвт удирдамжийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулсан “Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл-2020” нэгдсэн арга хэмжээний “Яараад яахав дээ” өдөрлөгийн хүрээнд замын хөдөлгөөнд оролцож буй иргэдэд аялал зугаалгаар явахдаа асаасан гал, татсан тамхи, машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, гол мөрөнд орохдоо согтуурлуулах ундаа хэрэглэсэн үедээ орохгүй байх,

хүүхдүүдээ тогтмол хараа хяналт тавьж анхаарал сэрэмжийг алдахгүй байх талаар зөвөлгөө санамж агч ажилласан.

“Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу Баруун-Урт сумын 7-р багт байрлах 9 дүгээр цэцэрлэгт гамшиг, ослын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын дагуу Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газартай хамтран гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, үнэлгээ хийсэн. Үнэлгээгээр тус цэцэрлэг барилга байгууламж, аюулгүй байдлын хувьд ногоон түвшинд буюу бага эрсдэлтэй гарсан байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулсан талаар: Онцгой байдлын ерөнхий газар болон Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс ирсэн урьдчилан сэргийлэх, цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг SMS SENDER IRS праграмм скайтелийн 3G модемийг ашиглан цаг алдалгүй Аймгийн ОК-ын гишүүд болон, сумдын Тамгын газрын дарга нар, малчин өрхүүдэд багц мессэжийн үйлчилгээг цаг алдалгүй хүргэсэн.

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг, аюулт үзэгдлийг цаг алдалгүй мэдээлэх, анхааруулах сэрэмжлүүлэх 2 удаагийн мэдээ мэдээллийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор үер усны ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг орон нутгийн 2 телевизээр нийт 4 өдөр, 10 удаагийн давталттай 40 удаа хүргэн ажилласан. Мөн Онцгой байдлын газрын цахим сайт, Sukhbaatar.uridchilansergiilehfacebook хаягаар цахим хэлбэрээр иргэдэд цаг үеийн мэдээллийг 1 удаа, орон нутгаас хэвлэгдэн гардаг Сүхбаатарын өнгө сонинд урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, тухайн үеийн мэдээ мэдээллийн талаар 6 удаа нийтлүүлэн мэдээ мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэн ажиллалаа.

Гал түймэр, гамшиг осолтой тэмцэх талаар: Гал түймэр унтраах, аврах 15, 47 дугаар анги нь томилгоот харуул ээлжинд 31 удаагийн 744 цагийн үүрэг гүйцэтгэх хугацаанд объектын гал түймрийн дуудлага 1 удаа, ус цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн дуудлагаар 1 удаа нийт 2 удаагийн дуудлагаар ажиллаж гал түймэр унтраах, аврах ажлыг зохион байгуулж ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 2/535 тоот үүргийн хэрэгжилтийн хүрээнд Гал унтраах тархалтын сургуулийг батлагдсан төлөвлөгөөний дагуу Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулдаг “Смайл зоогийн газар” “Түн булаг зоогийн газар” “Шарга зоогийн газар” “Их урсгал зоогийн газар” зэрэг байгууллагуудад шинэ төрлийн коронавирисын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тархалтын сургуулийг танхимын сургалтаар зохион байгуулсан.

Сургалтад аж ахуй нэг байгууллагаас 34 хүн хамрагдсан. Онцгой байдлын албанаас давхардсан тоогоор 18 албан хаагч оролцсон.

Мэргэжлийн хяналтын газар: Тус газраас Сүхбаатар аймагт ашиглагдаж байгаа гүүрийн байгууламжид давхардсан тоогоор 39 заалттай зөвлөмжийг Аймаг, сумдын засаг дарга нарт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Баруун-Урт суманд 9.1 км асфальтан замын угсралтын ажилд МХЕГ-ын даргын баталсан 01/53 дугаартай удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх шалгалт хийгдэж байна.

Түмэнцогт суманд 25 айлын орон сууцны барилга угсралтын ажилд МХЕГ-ын 01/120 дугаартай удирдамжийн хүрээнд, мөн Баруун-Урт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 45 айлын орон сууцны барилга угсралтын ажилд МХЕГ-ын даргын баталсан 01/102 дугаартай удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгах хүртэл барилга угсралтын үйл ажиллагааг түр зогсоогоод байна.

Түвшинширээ суманд 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ашиглалтын төлөв байдалд үзлэг шалгалт хийж холбогдох дүгнэлтийг гаргасан.

МХЕГ-ын дэд даргын баталсан 01/101 тоот удирдамжийн дагуу жуулчин тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд тандалт судалгаа хийсэн.

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 17/24 тоот хөтөлбөрийн дагуу Баруун-Урт сумын 5, 7-р багийн нутагт орших 3 аж ахуйн нэгжийн мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон хадгалалт, мал, түүхий эд боловсруулах үйл ажиллагаанд Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хог хаягдлын тухай хуулиуд болон холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах талаар зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

2020 оны ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажил эхлэж байгаатай холбогдуулан сумдын Засаг даргын тамгын газарт албан тоот хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн Онцгой байдлын газрын хүсэлтийн дагуу тус газрын Түмэнцогт суман дахь Улсын нөөцийн салбарын Баруун-Урт цэгийн өвс, тэжээлийн 2 агуулахын барилга байгууламжийн төлөв байдалд үзлэг шалгалт хийгдэж байна.

Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулах, зөвлөгөө зөвлөмж өгөх зорилгоор цэцэрлэг, сургуулиудад урьдчилан сэргийлэх шалгалт хийгдэж байна.

Байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд сүүлийн 14 хоногийн хугацаанд нийт 5 постер бэлдэж байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.

Мөн үер усны аюулаас сэрэмжлүүлэх постер, 2020-2021 оны хичээлийн жилийн сургалт үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын зөвлөмж болон коронавируст халдвараас сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээлэл, маскаа зүүцгээе-II аяны хүрээнд нийт 17 постер, зөвлөмжийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн лабораторит хими хор судлал, нян судлалын чиглэлээр 24 сорьцонд 107 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийснээс 3 сорьц эерэг дүнтэй гарсан.

Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил:

Баруун-урт: Азийн хөгжлийн банкнаас зарласан 5000 ам долларын бичил төсөлд Баруун-Урт сум шалгарч 12850,000 төгрөгний санхүүжилтийн гэрээ байгууллаа.

ЕБС-д хамрагдах 6 настан болон СӨББ-д эхлэн суралцагчдын мэдээлэл судалгааг гаргалаа. 2020-2021 оны Шинэ хичээлийн жилд СӨБ-д элсэн суралцах 3-5 настай 1946, ЕБС-д элсэн суралцах 6 настай 544 хүүхдүүд байна.

Цаг үеийн ажлууд: Сүхбаатар аймгийн прокурорын газрын мэдэгдэлийн дагуу багийн ажлын албанаас багийн хэсгийн байцаагчтай хамтран 12 иргэнийг хамруулсан хэсэгчилсэн сургалт, Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын ахмад Б.Тэгшжаргал, тус багийн хэсгийн байцаагч Х.Баттулга нартай хамтран “Иргэн таны мэдлэгт “ танхимын сургалтыг зохион байгуулж 25 иргэн, багийн засаг дарга багийн хэсгийн байцаагчтай хамт айл өрхөөр орж 5 иргэнд мэдээлэл, зөвлөмж хүргэн нийт 42 иргэнийг сургалтад хамруулсан. Энэхүү сургалтыг хүүхэд хохирох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчлийн болон эрүүгийн хуулийн талаар мэдлэг мэдээллээр хангах зорилгын хүрээнд зохион байгуулсан.

2-р багийн нутаг дэвсгэр дэх гэр хорооллын айл өрхүүдийн хогны менежментийг сайжруулах зорилгоор аймгийн Байгаль орчны газартай хамтран Цайрт Минерал ХХК-аас 200 ш пошкийг авч тус багийн гэр хорооллын 100 өрхөд тараасан.

Уртын гэгээ ОНӨААТҮГ-тай хамтран Жаргалан хотхон 27а,б,в, 36а, 36б, 48 айл, Одкон хотхоны шарилжийг цэвэрлэн голын талбайг цэвэрлэж оршин суугчдын эрүүл таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Сумын ЗДТГ, ИТХ-ын төлөөлөгч, Багийн ажлын алба хамтран Амгалан хорооллын худгийг төвийн цэвэр усны шугамд холбох ажлыг гүйцэтгүүлж, цахим системд холбон ухаалаг худагтай болгосон.

Шарилжгүй Баруун-Урт аяны хүрээнд “Билэгт тусч хүү” нөхөрлөлөөр нийтийн эзэмшлийн зам талбай болон орон сууцны голын зам дагуух шарилж устгах ажлыг хийж гүйцэтгүүлж байна.

Баяндэлгэр:

Төрийн удирдлагын чиглэлээр: Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой үндэсний их баяр наадмын үндэсний сурын харваанд түрүүлж “Монгол Улсын Мэргэн” цол хүртсэн тус сумын уугуул иргэн Л.Одсайханд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 1.1 сая төгрөгийг зарцуулсан.

“Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” журмын дагуу хээрийн судалгааны ажлыг 5 багийн 22 цэгт хийж тэмдэгжүүлж ажилласан.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Хөдөлмөр зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 18 ажилгүй иргэдийн мэдээллийг шинэчилсэн. Шинэ ажлын байранд 1 иргэнийг бүртгэн зуучилж мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Хүнсний эрхийн бичиг цахим хэлбэрээр 62 өрхийн 286 ирэнд 7408000 мянг.төгрөгийг олгосон.

“Нэг өрх- нэг хүүхэд” аяны хүрээнд засаг даргын нөөц сангаас зорилтот 5 өрхийн 5 хүүхдэд 363500 мянган төгрөгийн дүрэмт хувцсыг олгоод байна.

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэг-285,Урьдчилан сэргийлэх үзлэг-17, Гэрийн идэвхитэй хяналт-7, Гэрийн дуудлага-5, Идэвхитэй хяналт-61, Амбулатороор 236 иргэнд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүллээ. Лабораториор нийт- 131 иргэн үйлчлүүлсэн.

Хөдөө аж ахуй, байгаль орчин: Төл малд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажил сумын хэмжээнд нийт бод 5500, бог 112680 малд хийгдэхээс 5 аж ахуй нэгжийн урьдчилсан мэдээгээр бод 455, бог 11531 малд буюу 10% явагдаж байна.

Галба Өөш Долоодын говийн сав газрын захиргаатай хамтран сумын гадаргын усны тоо бүртгэлийг явуулж байна.

Төв хайрганы карьер 0.2462 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж, эвдрэлд орсон газар нутагт нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр: Засгийн газрын болон аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор сумын ЗДТГ-т “**Үйлчилгээний нэгдсэн төв**”-ийг байгуулан, операторчийн орон тоонд нэг албан хаагчийг шинээр томилон 2020.07.31 ний өдрөөс эхлэн ажиллуулж байгаа бөгөөд энэ хугацаанд нийт 54 үйлчилгээнээс 6 төрлийн үйлчилгээг 57 иргэнд үзүүлээд байна. Үүнд: а/. Жолоодох эрхийн оноо 2, б/. Жолоочийн лавлагаа 24, в/. Иргэний үнэмлэхний лавлагаа- 21, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт-6, г/. Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-2, д/. Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа-2 байна. Одоогоор төлбөргүй 14 үйлчилгээ үзүүлсэн, нийт 65700 төгрөгийн хураамжийг иргэдээс авч, дансанд нь төвлөрүүлсэн.

Орон нутгийн сонгууль болохтой холбогдуулан хурлын төлөөлөгчөөр нэр дэвших төрийн захиргааны 2 албан хаагч ажлаас чөлөөлөгдөж, дараагийн нөхөн сонгогдох 1 албан хаагчийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлээд байна.

Эрүүл мэнд: Хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох дэлхий өдрийг тохиолдуулан “ЭРҮҮЛ ЭХ ДЭЛХИЙН ТӨЛӨӨ, ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛОЛТЫГ ДЭМЖИЦГЭЭ ”уриан доор хөхүүл болон жирэмсэн 25 эхчүүдэд зөвөлгөө мэдээллийг түгээн ажилласан.

Коронавируст халдвараас сэргийлэх ажлын хүрээнд 85 иргэдэд сургалт ,сурталчилгааг явуулсан.

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгалтын , шинжээчийн баг тус эрүүл мэндийн төвд хяналт үнэлгээ хийж ажилласан.

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2020 оны А/477, сумын засаг даргын А/65 дугаар захирамжаар аймаг сумдын нөөц өвс хадлан бэлтгэх ажил эхлээд байна. Үүнд сумын

15 иргэн, аж ахуйн нэгж нийтдээ 2800 га талбайд хадлан хадах ба аймгийн зөвшөөрөлтэй 10 хадлангийн салаанаас 6 нь 1350 га-д үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Малын бруцеллөз өвчний тарилгад 5 групп ажиллаж байгаа бөгөөд одоогоор 22460 хурга, 6815 ишиг, 2100 тугал тарилгад хамрагдсан. Мөн энэ тарилгатай хамт орон нутгийн тарилга болох дотрын халдварт хордлого, цусан халдварт, боом, сахуу, галзуу зэрэг тарилга хийгдэж байна.

Бог малын угаалганд 31200 мал оруулж, уг ажил үргэлжилж байна.

Мөнххаан:

Төрийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Томилогдсон албан тушаалтан албан хаагчидтай албан тушаалтын тодорхойлолтод заасан шаардлагад дүн шинжилгээ хийж мөн ТҮ-ний албан тушаалын тодорхойлолт болон гэрээт, гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа албан хаагчидтай гэрээг шинэчилэн боловсруулан ажилласан.

Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулан аймагт тушаасан.

Байгаль хамгаалал ан амьтаны чиглэлээр: Тус сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэлээсэг хадлан бэлтгэх газар болон тарвага нутагшуулсан газруудад хяналт тавьж ажилласан ба илэрсэн зөрчлийг туххай бүр арилгуулах арга хэмжээг авлаа.

Уул уурхай, газрын хэвлий, ашигт малтмалын чиглэлээр: Байгаль орчин аялал, жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хамтран баталсан “Нөхөн сэргээлт 2020” ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2020 оны А/446 дугаар захирамжийн дагуу тус сумын “Баруун-сүүж” хэмээх газрын 0.2 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийхэд шаардлагатай шатах тослох материалын зардлыг БОАЖГ-т газарт хүргүүлсэн.

Газар зохион байгуулалтын чиглэлээр: 8 сард 5 иргэний өргөдөл хүлээн авч, 23 иргэний хашаа байшингийн хэмжилт хийгдсэн, мөн бэлчээрийн фотомониторингийн 20 цэгийн хээрийн судалгааг хийж гүйцэтгэн программд оруулж байна. 7 иргэний газар хураалт хийгдэж шинээр иргэнд зааж өгсөн

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Малчин болон мал бүхий 596 иргэний 134622 кг ноосны падаан шивж дуусгасан.

Нийгмийн даатгал: Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэвэрийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг 120 иргэнд сурталчилж 18 даатгуулагчдын нийт 36925.0 төгрөгийн хүсэлтийг хүлээн авснаас 11 даатгуулагчдын 20946.0 төгрөг төвлөрсөн.

0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн сайн дурын даатгалын талаар нийт 95 иргэнд мэдээлэл хүргэж ажилласанаас нийт 30 даатгуулагч хамрагдаж 1286.2 төгрөг төвлөрсөн.

Өндөр настны тэтгэвэр 45, тахир дутуугийн тэтгэвэр 4, тэчээгчээ алдсаны тэтгэвэр 3 шинээр тогтоогдсон. Эрүүл мэндийн даатгал 287 иргэн даатгуулж 14817.7 төгрөг төвлөрсөн. Нийт 6 төсөвт байгууллага, 20 ААН байгууллагаас 302206.7 төгрөгийн НДШ төвлөрсөн байна.

Наран:

Сумын аюулгүй нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд Хилийн цэргийн 0184-р ангийн захиргаа болон иргэнтэй гурвалсан гэрээ байгуулж ажлыг эхлүүлээд байна.

Эрүүл мэнд: 0-6 сартай хүүхэдтэй 15 эцэг эхэд “Хүүхдийг хөхөөр хооллохын ач тус”, “COVID-19 ба жирэмсэн”, “Эх ургийн анагаах ухааны асуудал” зэрэг сургалтыг зохион байгууллаа.

“ЭРҮҮЛ ЭХ ДЭЛХИЙН ТӨЛӨӨ СҮҮГЭЭР ХООЛОЛТЫГ ДЭМЖИЦГЭЭЕ” аяныг өрнүүлж төлөвлөгөө гарган ажиллаа.

Түвшинширээ:

Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хуралдааныг хийж хуралдаанаар үнээний ферм байгуулах хүсэлтэй 3 иргэний төслөөс Ч.Анхбаярын төслийг дэмжих шийдвэр гарч тус төсөлд 40.0 сая төгрөг, мөн 1-р багийн иргэн П.Мөнхтулгын гар утасны завсар төсөлд 6,0 сая төгрөгний санхүүжилт олгохоор тус тус шийдвэрлэлээ.

Сумын ЗДТГ-аас ЕБС-ийн бага боловсрол хариуцсан менежертэй хамтран шинээр 1-р ангид элсэн суралцах 6 настай 81 хүүхдүүдийн тулгалтыг хийж ажилласан ба мөн цэцэрлэгийн насны 3-5 насны хүүхдийн тулгалтыг хийж, 5 настай бэлтгэл бүлгийн 84 хүүхдүүдийг бүрэн хамруулах тал дээр цэцэрлэгийн арга зүйчтэй хамтран ажиллаж байна.

2019-2020 оны МАА-н болон төв суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2020 оны 8 сарын байдлаар сумын нийт хүн ам 3400 болж, сумын нийт өрх 974 болоод байна.

ҮСХ-ноос Коронавирусийн өрхөд үзүүлж буй нөлөөллийг судлах зорилгоор УТСАНД СУУРИЛСАН СУДАЛГААГ 2018 оны ӨНЭЗС-нд хамрагдсан өрхүүдийн дунд 2020 оны 8-р сарын 27-оос 9-р сарын 7-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар болсон. Түүврээр сонгогдсон 8 өрхийн утасны жагсаалтыг тулгаж, өрхөд судалгааны талаарх мэдээллийг хүргэн, аймгийн статистикийн хэлтэст хүргүүлээд байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Өгөөмөр багийн нутаг Баян-Өндөр, Бор-Өндөр, Хөнхөр цант, Ар Өлзийт зэрэг нутгуудаар нутаглаж байгаа Баяндэлгэр сумын 18 өрхөд өвөлжөө хаваржааны бэлчээр нутгийг 7 хоногийн хугацаанд чөлөөлөх мэдэгдэл хүргүүлээ.

Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ сумын Засаг даргын захирамжийн дагуу хийгдэж байна. Мал угаалгын ажилд 4 ажлын хэсэг гарч 8 угаалгын вананд мал сүргийг угааж байна. Одоогийн байдлаар бод 430, бог 98700 нийт 99130 толгой мал угаалганд хамрагдаж, сумын хэмжээнд 33 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн даатгал, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр: 2020 оны 6 дугаар сарын 23-аас эхлэн ЕБС нь хичээлийн 1-р байранд 584 сая төгрөгийн өртөгтэй их засварын ажил хийгдэж одоогоор 98%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Эрүүл мэндийн төв: Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлж байгаатай холбоотойгоор хүүхдийн цагаан хорхойн урьдчилан сэргийлэх үзлэгийг нийт хүүхдүүдийн дунд хийж байна. Үүнд цэцэрлэгийн насны 200, сургуулийн насны 50 орчим хүүхэд хамрагдаад байна.

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр: Засаг даргын А/80 дугаар захирамжаар Хог хаягдлын менежментийг сайжруулах, хогийн нэгдсэн цэгт эмнэлэгийн аюултай хог хаягдлын устгалын цэг байгуулж зориулатын дагуу тэмдэгжүүлэх ажлыг 8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн.

Засаг даргын А/82 дугаар захирамжаар 4 дүгээр багийн Хүүхдийн тоглоомын талбайг ОНХСангийн 18 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж засварлаж ашиглалтад оруулсан.

Сумын төвийн төв талбайд 38 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар LED дэлгэц байршуулан Covid-19 шинэ төрлийн вирусээс урьдчлан сэргийлэх анхааруулга, зөвлөмжийг мэдээллэж байна.

Хөдөө аж ахуй: Засгийн Газрын 2019 оны 343-р тогтоолын дагуу хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт 4 үйлдвэрт тушаасан 130 малчин, мал бүхий өрхийн падааныг аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.

Сумын Засаг даргын “Хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах тухай” А/79 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв: Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд 10 эмэгтэй, Хөхний үзлэгт 34 үйлчлүүлэгч хамрагдаад байна.

Говь мастер, Эф жи уурхайд шинээр ирсэн 17 ажилтанд үзлэг хийж элэгний В, С вирусын болон серологийн шинжилгээ хийж ажлын байранд үзүүлэх анхан шатны тусламж хичээлээр сургалт явуулсан.

Халзан:

Төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Орон нутгийн сонгуульд өрсөлдөхөөр албан тушаалаас чөлөөлөгдсөн 1 албан хаагчийн мэдүүлэгийг Авилгатай тэмцэх газарт хянуулж шийдвэрлэгдсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Цэцэрлэгийн барилга 95%-тай явагдаж байна.

Хууль эрх зүй: ЖДҮ, сум хөгжүүлэх сангийн мэргэжилтэн 2020 онд сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн мэдээлэл, зээлийн эргэн төлөлт, үйлдвэрлэлийн талаарх сургалтыг зохион байгуулав.

ИТХурлын сонгуультай холбоотойгоор төрийн албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтууд, төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу сургалт зохион байгуулав. Мөн бусад төрийн байгууллагын дарга, удирдлагуудад танилцуулж ажилласан.

Боловсрол: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дотуур байрны Их засварын ажил хийгдэж дууслаа.

Шинэ цэцэрлэгийн барилгын ажил 90%-тай явагдаж байна.

Хөдөө аж ахуй: Ээмэгжүүлсэн бог малны хээлтүүлэгчийг цахим бүртгэлд бүртгэж байна.

08-р сарын 20-ны байдлаар нийт 20 зээлдэгч байгаагаас зээлийн эргэн төлөлтийн орлого 4 хүнээс 988,762 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Байгаль орчин: Үерийн улмаас эвдэрсэн замыг засварлаж тэмдэг тэмдэглэгээ байршуулав.

Эрдэнэцагаан:

Удирдлага зохион байгуулалт, хууль эрх зүйн хүрээнд: Сумын Засаг даргын 2020 оны А/142, 143,144,145,146 дугаар захирамжуудаар “Сумын баяр наадмын төв талбай” барих, Хүүхдийн 1-р цэцэрлэгт “Гадна, дотор тоглоом” нийлүүлэх, сумын төвд “Хог зөөврийн авто машин” худалдан авах, сумын төвд “ 04 кв-ын 2.5 км ЦДАШ” тавих, Егүзэр Хутагт мэндэлсэний 150 жилийн ойг тохиолдуулан “Хутагтын музейн барилгын засвар” зэрэг гүйцэтгэх ажлын тендер зарлан сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж ажилдаа ороод байна.

Аймаг сумын өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор бэлтгэж буй хадлан бэлтгэлийн ажилд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Орон нутгийн замын хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах Сумын засаг даргын 2020 оны А/135 дугаар захирамжийн дагуу “Яараад яахав дээ” ухуулга нөлөөллийн аяны нээлтийг хийж, цагдаагийн тасагтай

хамтран төрийн байгууллагуудын албан хаагчид, иргэдэд сургалт сурталчилгааг хийн ажиллаж байна.

Эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” зөвлөмж, гарын авлага бэлтгэн иргэдэд 300 ширхэгийг хувиалан тараав.

Онцгой байдлын Ерөнхий газар, Мерси Кор олон улсын байгууллага хамтран гамшгаас хамгаалах сургалтыг тус суманд зохион байгуулж, сумын эрсдэлийн үнэлгээний төлөвлөгөөний төсөл, Сургууль цэцэрлэгийн Гамшигаас хамгаалах төлөвлөгөөний төсөл боловсруулсан ба сургалтад 45 төрийн албан хаагч хамрагдлаа. Мөн Гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг чадварыг олон нийтэд олгох “Бэлэн бай” сургалтад 15 албан хаагч сургагч багшаар бэлтгэгдэж сертификатаа гардан авлаа.

Төсөв, санхүү: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд ААНБ-аас хандив тусламжаар 20494.0₮ хандив цугларсанаас гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах эрсдэлийг бууруулахад зориулж нийт 21332,9₮, зардал гарч цугларсан хандиваас 19298.3₮, гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 2034.6₮ зарцуулсан байна.

Боловсрол соёлын байгууллагын хүрээнд: 1-р ангид орох сурагчдын бүртгэл явагдаж байна.

Хорио цээрийн дэглэмийн үед зохион байгуулагдсан теле хичээлд дүн шинжилгээ хийж анализ хийсэн.

Бага ангийн багш нар болон ажилчид эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 97%- тай хамрагдав. Сурах бичгийн татан авалт 100% хийгдсэн.

9-р ангийг нийт 102 суралцагч төгссөнөөс мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд 24 суралцагчийн шилжүүлгийг хийгээд байна.

Хүүхдийн 1-р цэцэрлэг: 50:50 харьцаа бүхий шинэ хогийн цэгийг шинээр барьж ашиглалтанд орууллаа.

Хүүхдийн 2-р цэцэрлэг: Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эхлүүлж уурын зуухны бүрэн бүтэн байдал болон халаалтын шугамд үзлэг шинжилгээн хийж 5 хэсгийн 13 шугамд засвар үйлчилгээг хийлээ.

Соёлын төв: Соёлын төвийн дээврийн засварын ажлыг Сүхбаатар аймгийн “Ёст бэйс сервэс” ХХК компани хийж гүйцэтгэлээ. Хутагтын 150 жилийн ойд зориулан “Егүзэр хутагт Хатагины хар сүлд тахилгын өргөө”-г засварлахаар төлөвлөн ажиллаж байна. “УГИЙН БИЧИГ-УДМЫН БАХАРХАЛ” тэмцээнийг зохион байгуулсан ба нийт 11 хүний материал ирсэнээс 2 хүнийг шалгаруулсан.

Эрүүл мэнд: 711 хүнд үзлэг хийснээс ,122 урьдчилан сэргийлэх үзлэгт , идэвхитэй хяналтаар 109 , стационараар нийт 32 хүнийг хэвтүүлэн эмчлүүлээд байна.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 1138 эмэгтэй хамрагдаж үзлэгийн хувь 66,1 % байна. Нийт 179 өвчлөл илэрсэнээс 159-ийг эмчлэн эрүүлжүүлж, эрүүлжилтийн хувь 88,8% байна. Өртөмтгий бүлгийн 826 эмэгтэй ЖСА хэрэглэж байгаа ба 83,7% байна.

Сувилахуйн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 3227 хүнд үзүүлсэн байна. Үүнээс: Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 350, өдрийн эмчилгээнд 10 хүн, амбулаторийн тусламж үйлчилгээ 287, гэрийн эргэлт 26 хүнд тус тус үзүүлсэн. Сувилахуйн стандарт хэрэгжилтийг мөрдөн ажиллалаа.

Хот хоорондын шууданд хяналт тавьж үзлэг хийх эмч гарын хуваарийг гарган шуудангаар зорчигчдод урьдчилан сэргийлэх үзлэг хийж гар ариутгаж, халуун үзэн ажиллаж байна. Мөн эмнэлгээр үйлчлүүлж байгаа ард иргэдэд гарын авлага тарааж 70515458 утсанд хандахыг зөвлөн ажиллаж байна.

Хүн ам зүй, нийгмийн хамгаалал: Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэлийн лавлагаагаар Төрсний гэрчилгээний -1, Нийгмийн даатгалын шимтгэл-3, бүгд 4 лавлагаа гаргасан байна.

2019 оны жилийн эцсийн Хүүхэд хамгааллын статистик тоон судалгаагаар 0-17 насны нийт 2477 хүүхдээс хагас, бүтэн өнчин -155, ээжтэйгээ амьдардаг-180, аавтайгаа амьдардаг- 24, ХБХ-ийн тоо-8, төрөлхийн ХБХ-ийн тоо-7, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо-0, мэдээг гаргаж ГБХЗХГ-т хүргүүллээ.

Хүнс, хөдөө аж ахуй: Сумын хэмжээнд 32000 толгой мал төллөсөн, том малын хорогдол 160 толгой мал үүнээс өвчнөөр 11 мал хорогдсон байна. Энэ сард малын хорогдол нэмэгдээгүй.

Энэ онд 7 га талбайд төмс хүнсний ногоо тариалаад байна. Өвс тэжээлийн нөөц бэлтгүүлэх ажлыг төлөвлөсөн энэ онд 100 тн өвс бэлтгэнэ. Одоогийн байдлаар Газрын даамалаас 7 ААН өвс бэлтгэх гэрээ хийсэн байна.

Сумаас 80 км газар хадлангуудыг гаргасан

Байгаль орчин: Аймгийн БОАЖГ болон Буйр нуур Мэнэнгийн сав газартай хамтарч сумын хэмжээнд гарсан энгийн уурхайн худаг болон гүн өрмийн худгуудыг тоолох ажлыг хөдөөгийн 5 багт 3 өдөр зохион байгуулж ажиллалаа. Тооллогын дүнгээр энгийн уурхайн худаг-25, гүн өрмийн худаг-18, нуур цөөрөм-28 нэмж тоологдсон байна.

Мөн тус газартай хамтран сумын хэмжээнд зориулалтын бус газар хаясан эзэнгүй 25 тн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн, ландфиллын аргаар булж устгасан байна.

Хэцүү, Лхачинванд зэрэг газруудад буга согоонд хужир шүү тавьж өгөх ажлыг зохион байгуулж нийт 5тн хужир тараан тавилаа.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар